

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2025 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/009/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Алтай хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Н.Гэрэлмаа
Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр).....	3
Гурав. Аудитын илрүүлэлт	6
3.1 Залруулсан алдаа:.....	6
3.2 Албан шаардлага	7
3.3 Зөвлөмж	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026. 03. 11 № 126

танай _____ -ны № _____ -т

ИННОВАЦИ СУДАЛГАА БИЗНЕС
ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ё.НАРАНГАРАВ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хязгаарлалттай” санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй. Үүнд:

- Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд нь төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй,
- Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд 20,000.0 мянган төгрөгийн өөрийн орлого төлөвлөсөн боловч биелэлтийг ханган ажиллаагүй,
- Хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулан 2,000.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн,
- Тайлант онд 19,554.9 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,
- Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, дүн зөрүүтэй,

822511000384

- "Мазаалай монголдой 2D анимейшн" төслийн хүрээнд "Storyboard хийх, дүрүүдийг смүүти хөдөлгөөнд бүрэн оруулах" 18,000.0 мянган төгрөгийн ажлын гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 25-нд, "Дүрүүдийн дуу оруулалт" 3,000.0 мянган төгрөгийн ажлын гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 01-нд, "Өрөөнүүдийн засвар хийх ажлын гэрээ"-ний хугацаа 2025 оны 10 дугаар сарын 26-нд тус тус дууссан боловч гэрээг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийг хүлээн аваагүй, данс бүртгэлд тусгаагүй,
- Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 02/136 дугаартай 1,980.6 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.7 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэрт соён гэгээрүүлэгч, орчуулагч, зохиолч, яруу найрагч Мишигийн Цэдэндоржийн нэрэмжит Хуурын эгшиг яруу найргийн наадам, соёлын биет бус өвийн үндэсний бүртгэлд багтсан "Монгол Жангар хайлах" арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан байна.

Тус ажлын хүрээнд тайз, дэлгэцийн засалт, анонс, хэвлэлийн эх бэлтгэл, урилга, шторк, зарын постерууд, заалны зохион байгуулалт, 3D зураг хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэжээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 19,635.2 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж бэлтгэж, байгууллагын байрлах 2 өрөөг 5,910.0 мянган төгрөгөөр засварласан байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан, хавсралтаар газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөний нийт орлогыг 398,511.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 378,500.0 мянган төгрөгөөр батлуулсан байна.

Тус байгууллага нь орон нутгийн төсвөөс 100.0 хувь санхүүждэг бөгөөд тайлант онд авах дэмжлэгийг 82,999.4 мянган төгрөгөөр дутуу авч, 10,593.3 мянган төгрөгийн өр үүссэн байна. Өөрийн орлогоос 20,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэлийг ханган ажиллаагүй байна.

Бусад асуудал

Тайлант онд 8 зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 49 арга хэмжээг бүрэн, 5 арга хэмжээг 90.0 хувь, 5 арга хэмжээг 80.0 хувь буюу нийт дүнгээр 97.4 хувиар биелүүлж, биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн боловч ажлыг дүгнээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	19,780,597.37	909,714.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	19,780,597.37	909,714.29
3121	Төгрөг	19,780,597.37	909,714.29
31213	Арилжааны банк дахь харилцах	19,780,597.37	909,714.29
33	АВЛАГА	1,980,626.00	1,980,626.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	1,980,626.00	1,980,626.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,683,465.00	5,781,465.00
351	Түүхий эд материал	305,000.00	400,000.00
35110	Тусгай зориулалттай материал	305,000.00	400,000.00
354	Хангамжийн материал	4,378,465.00	5,381,465.00
35410	Бичиг хэргийн материал	-	205,500.00
35420	Аж ахуйн материал	3,132,800.00	3,132,800.00
35440	Түлш, шатах тослох материал	-	670,000.00
35460	Хүнсний материал	-	27,500.00
35470	Бусад хангамжийн материал	1,245,665.00	1,345,665.00
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	26,444,688.37	8,671,805.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,637,556.71	35,956,094.45
392	Биет хөрөнгө	27,582,890.18	33,725,427.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,021,000.00	64,656,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,998,192.22)	(38,964,994.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,108,700.00	13,108,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,565,284.14)	(5,991,143.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,500,000.00	5,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,483,333.46)	(4,583,333.50)
393	Биет бус хөрөнгө	6,054,666.53	2,230,666.49
39301	Програм хангамж	19,120,000.00	19,120,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(13,065,333.47)	(16,889,333.51)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	33,637,556.71	35,956,094.45
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	60,082,245.08	44,627,899.74
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	391,597.00	10,593,333.44
413	Өглөг	391,597.00	10,593,333.44
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	282,221.00	5,893,333.44
4136	Бусад өглөг	109,376.00	4,700,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	109,376.00	4,700,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	391,597.00	10,593,333.44
51	Засгийн газрын хувь оролцоо	59,690,648.08	34,034,566.30
512	Хуримтлагдсан үр дүн	59,690,648.08	34,034,566.30
51210	Өмнөх үеийн үр дүн	61,907,969.85	59,690,648.08
51220	Тайлант үеийн үр дүн	(2,217,321.77)	(25,656,081.78)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	59,690,648.08	34,034,566.30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	60,082,245.08	44,627,899.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2024 оны12-р сарын 31	2025 оны12-р сарын 31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	341,306,700.00	296,115,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,306,700.00	295,500,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	341,306,700.00	295,500,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	615,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	-	615,000.00

12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	-	36,464.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	36,464.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	36,464.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	36,464.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	341,306,700.00	296,152,064.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	343,524,021.77	321,808,145.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,524,021.77	319,018,145.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,845,983.00	210,366,479.34
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	235,845,983.00	210,366,479.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,006,781.78	27,205,341.55
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	29,006,781.78	27,205,341.55
2104	Хангамж, бараа материалын зардал	8,391,460.00	13,042,840.00
210401	Бичиг хэрэг	-	5,554,190.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,230,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	128,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,130,650.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	8,391,460.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,255,000.00
210604	Урсгал засвар	-	6,255,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,130,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,130,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,242,032.00	27,082,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	27,082,000.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	1,640,000.00	-
210813	Бусад зардал /ТӨҮГ/	53,602,032.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,037,764.99	30,936,484.89
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	13,619,822.63
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,037,764.99	17,316,662.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,790,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,790,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,790,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	343,524,021.77	321,808,145.78
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(2,217,321.77)	(25,656,081.78)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(2,217,321.77)	(25,656,081.78)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	2024 оны12-р сарын 31	2025 оны12-р сарын 31
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	341,306,700.00	296,115,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,306,700.00	295,500,600.00
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	341,306,700.00	295,500,600.00
1330	Төсвийн захирагчдаас	-	615,000.00
133004	Дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон санхүүжилт	-	615,000.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	-	36,464.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	36,464.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	36,464.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	36,464.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	341,306,700.00	296,152,064.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	273,724,925.22	295,387,747.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,724,925.22	292,597,747.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,451,498.00	204,994,140.83

210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	235,451,498.00	204,994,140.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,009,667.22	27,075,943.62
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	29,009,667.22	27,075,943.62
2104	Хангамж, бараа материалын зардал	9,263,760.00	9,308,200.00
210401	Бичиг хэрэг	-	1,907,700.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	128,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,372,500.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	9,263,760.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,255,000.00
210604	Урсгал засвар	-	6,255,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,130,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,130,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	22,382,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	22,382,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,452,462.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	18,452,462.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	2,790,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,790,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,790,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (2)	<u>273,724,925.22</u>	<u>295,387,747.08</u>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>67,581,774.78</u>	<u>764,316.92</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	19,635,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	19,635,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	19,635,200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	19,635,200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(19,635,200.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	67,581,774.78	(18,870,883.08)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,440,854.59	19,780,597.37
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,780,597.37	909,714.29

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	61,907,969.85	61,907,969.85
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	61,907,969.85	61,907,969.85
C19	Тайлант үеийн үр дүн	-	-	(25,656,081.78)	(25,656,081.78)
C20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	34,034,566.30	34,034,566.30

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Төсвөөс санхүүжих	378,500,000.00	295,500,600.00	82,999,400.0	78.1
Өөрийн орлого	20,000,000.00	-	20,000,000.0	0.0
Өмнөх оны үлдэгдэл	11,273.00		11,273.0	0.0
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт		615,000.00	(615,000.0)	
Бусад орлого		36,464.00	(36,464.0)	
ОРЛОГО	398,511,273.00	296,152,064.0	103,010,673.0	74.3
1.2 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			-	
1.3 Нийт ашиг	398,511,273.00	296,152,064.00	103,010,673.00	74.3
Цалин	237,949,000.00	204,994,140.83	32,954,859.2	86.2
Байгууллага төлөх НДШ	46,900,000.00	27,075,943.62	19,824,056.4	57.7
Бичиг хэрэг	3,985,000.00	1,907,700.00	2,077,300.0	47.9
Тээвэр шатахуун	4,200,000.00	3,900,000.00	300,000.0	92.9
Шуудан холбоо	2,000,000.00	128,000.00	1,872,000.0	6.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	3,372,500.00	1,627,500.0	67.5
Урсгал засвар	6,000,000.00	6,255,000.00	(255,000.0)	104.3
Дотоод албан томилолт	5,366,000.00	4,130,000.00	1,236,000.0	77.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,200,000.00	22,382,000.00	2,818,000.0	88.8
Бараа үйлчилгээний бусад зардал	5,300,000.00	18,452,462.63	(13,152,462.6)	348.2
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	-	3,000,000.0	0.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,300,000.00	2,790,000.00	1,510,000.0	64.9
Багаж хэрэгсэл	19,700,000.00		19,700,000.0	0.0
Байрны түрээс	9,600,000.00	-	9,600,000.0	0.0
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	378,500,000.00	295,387,747.08	83,112,252.92	78.0
1.5 Үндсэн үйл ажиллагааны ашиг /алдагдал/	20,011,273.00	764,316.92	19,898,420.08	3.8
3. Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	20,011,273.00	764,316.92	19,898,420.08	3.8

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар 540,806.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

3.1 Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байлын тайланд авлагыг 36.5 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмжийг 3,885.0 мянган төгрөгөөр, элэгдлийн зардлыг 25.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, бусад үндсэн хөрөнгийг 265.0 мянган төгрөгөөр, программ хангамжийг 3,620.0 мянган төгрөгөөр, элэгдлийн зардлыг 1,630.4 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 1,691.8 мянган төгрөгөөр тус тус илүү,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 36.5 мянган төгрөгөөр, ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ зардлыг 14,002.9 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 436.7 мянган төгрөгөөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлыг 261.5 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 6,195.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 4,130.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,378.8 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 2,790.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, үндсэн цалинг 14,002.9 мянган төгрөгөөр, урсгал засварыг 2,790.0 мянган төгрөгөөр, бараа материал худалда авах зардлыг 250.0 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 11.5 мянган төгрөгөөр, зочин төлөөлөлгч хүлээн авах зардлыг 4,130.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 2,955.0 мянган төгрөгөөр, хүүний орлогыг 36.5 мянган төгрөгөөр, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 6,055.5 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасныг залруулсан.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 716,325.5 мянган төгрөгийн 65 мэдээллээс, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, цалингаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээ нийт 503,368.3 мянган төгрөгийн 11 мэдээллийг тус тус мэдээлээгүйг нөхөн байршууллаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 65,719.3 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 65,719.3 мянган төгрөгийн 8 зөрчил² илэрч зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 4 зөвлөмж, 2 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

Нэг. Байгууллагын инноваци хариуцсан ажилтны дансаар дамжуулан төлбөртэй аппликейшн, пэйж сайтын үнэ 2,000.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хамаарал бүхий этгээдийн дансаар дамжуулан гүйлгээ хийж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Хоёр. "Мазаалай монголдой 2D анимейшн" төслийн хүрээнд "Storyboard хийх, дүрүүдийг смүүти хөдөлгөөнд бүрэн оруулах" 18,000.0 мянган төгрөгийн ажлын гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 25-нд, "Дүрүүдийн дуу оруулалт" 3,000.0 мянган төгрөгийн ажлын гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 01-нд, "Өрөөнүүдийн засвар хийх ажлын гэрээ"-ний хугацаа 2025 оны 10 дугаар сарын 26-нд тус тус дууссан боловч гэрээг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийг хүлээн аваагүй, данс бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хангаж ажиллах", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Storyboard хийх, дүрүүдийг смүүти хөдөлгөөнд бүрэн оруулах" гэрээний 2.5 дахь заалт, "Дүрүүдийн дуу оруулалт" гэрээний 2.5 дахь заалт, "Өрөөнүүдийн засвар хийх ажлын гэрээ"-ний 4.2, 5.2 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээ дүгнээгүй, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Гурав. Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 02/136 дугаартай 1,980.6 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй, тайлант онд 10,593.3 мянган төгрөгийн өртэй ажилласан нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 03 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ-ын дүрмийн 11.1.1-т "Говь-Алтай аймгийн инноваци судалгаа бизнес хөгжлийн төв" УТҮГ нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүртгэл хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг үйлдвэрийн газрын Гүйцэтгэх захирал хариуцна", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг биелүүлээгүй, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн захирал Ё.Нарангарав, нягтлан бодогч О.Оюунтунгалаг нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд 19,554.9 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй,

үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмжийг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

Хоёр. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын төсвөөс хүргэлт үйлчилгээний сайтын зардалд 528.0 мянган төгрөг, хөөсөн хэвлэлд 636.4 мянган төгрөг, төлбөртэй апп, пэйж сайтын төлбөрт 2,000.0 мянган төгрөг, нийт 3,164.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зохион байгуулсан үйл ажиллагааны тайлангүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх, зарцуулалтыг дахин хянаж холбогдох арга хэмжээг авах.

Гурав. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд 20,000.0 мянган төгрөгийн өөрийн орлого төлөвлөсөн боловч биелэлтийг ханган ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөг ханган ажиллах.

Илрүүлэлт: Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, дүн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг чанартай хийж тооцоог бодож илтгэх хуудсаар тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв	Санхүүгийн байлын тайланд авлагыг 36.5 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмжийг 3,885.0 мянган төгрөгөөр, элэгдлийн зардлыг 25.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, бусад үндсэн хөрөнгийг 265.0 мянган төгрөгөөр, программ хангамжийг 3,620.0 мянган төгрөгөөр, элэгдлийн зардлыг 1,630.4 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 1,691.8 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.	1	7,207.2	-	-	1	7,207.2	1	7,207.2	-	-	-	-
	Мөнгөн гүйлгээний тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 36.5 мянган төгрөгөөр, ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ зардлыг 14,002.9 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 436.7 мянган төгрөгөөр, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлыг 261.5 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 6,195.0 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 4,130.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,378.8 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлыг 2,790.0 мянган төгрөгөөр тус тус дутуу, үндсэн цалинг 14,002.9 мянган төгрөгөөр, урсгал засварыг 2,790.0 мянган төгрөгөөр, бараа материал худалда авах зардлыг 250.0 мянган төгрөгөөр, хоолны зардлыг 11.5 мянган төгрөгөөр, зочин төлөөлөлгч	1	30,231.4	-	-	1	30,231.4	1	30,231.4	-	-	-	-

Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	хүлээн авах зардлыг 4,130.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 2,955.0 мянган төгрөгөөр, хүүний орлогыг 36.5 мянган төгрөгөөр, нийт цэвэр мөнгөн гүйлгээг 6,055.5 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан.											
	Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 716,325.5 мянган төгрөгийн 65 мэдээллээс, бонд, зээл, ерийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, цалингаас бусад 5 саяаас дээш орлого, зарлагын гүйлгээ нийт 503,368.3 мянган төгрөгийн 11 мэдээллийг тус тус мэдээлээгүй.	1	503,368.3	1	503,368.3	-	-	1	503,368.3	-	-	-
Дүн		3	540,806.9	1	503,368.3	2	37,438.6	3	540,806.9	-	-	-

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв	Тайлант онд 19,554.9 мянган төгрөгийн компьютер техник хэрэгсэл бэлтгэсэн боловч цахим дэлгүүрээс худалдан аваагүй.	1	19,554.9	-	-	-	-	1	19,554.9	-	-
	Байгууллагын төсвөөс хүргэлт үйлчилгээний сайтын зардалд 528.0 мянган төгрөг, хөөсөн хэвлэлд 636.4 мянган төгрөг, төлбөртэй аппликейшн, пэйж сайтын төлбөрт 2,000.0 мянган төгрөг, нийт 3,164.4 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, зохион байгуулсан үйл ажиллагааны тайлангүй.	1	3,164.4	-	-	-	-	1	3,164.4	-	-
	Байгууллагын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд 20,000.0 мянган төгрөгийн өөрийн орлого төлөвлөсөн боловч биелэлтийг ханган ажиллаагүй.	1	20,000.0	-	-	-	-	1	20,000.0	-	-
	Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, дүн зөрүүтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Байгууллагын инноваци хариуцсан ажилтны дансаар дамжуулан төлбөртэй аппликейшн, пэйж сайтын үнэ 2,000.0 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн.	1	2,000.0	-	-	1	2,000.0	-	-	-	-
	"Мазаалай монголдой 2D анимейшн" төслийн хүрээнд "Storyboard хийх, дүрүүдийг смүүти хөдөлгөөнд бүрэн оруулах" 18,000.0 мянган төгрөгийн гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 25-нд, "Дүрүүдийн дуу оруулалт" 3,000.0 мянган төгрөгийн гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 01-нд, "Өрөөнүүдийн засвар хийх ажлын гэрээ"-ний хугацаа 2025 оны 10 дугаар сарын 26-нд тус тус дууссан боловч гэрээг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийг хүлээн аваагүй, данс бүртгэлд тусгаагүй.	1	21,000.0	-	-	1	21,000.0	-	-	-	-

Говь-Алтай аймгийн Инноваци судалгаа бизнес хөгжлийн төвийн 2025 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	Тус байгууллага жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд нь төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 02/136 дугаартай 1,980.6 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ аваагүй, тайлант онд 10,593.3 мянган төгрөгийн ертэй ажилласан.	2	-	-	-	-	-	-	-	2	-
	Дүн	8	65,719.3	-	-	2	23,000.0	4	42,719.3	2	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТБОНӨГ		1				1		
	НИЙТ		1				1		